Сонгинохайрхан дүүргийн тав хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлын өнөөгийн байдал ба нялхас, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөлтийн байдалд хийсэн үнэлгээ

Б.Энхжаргал[1], Г.Оюунболор[1], Ж.Отгонболд[2], Э.Есүү[3], З.Ганчулуу[4]

[1]АШУҮИС, НАСС
[2] АШУҮИС, Био-АС
[2,3]Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар
[4]Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг
Цахим шуудан: enhuush0003@gmail.com, Утас: 90088010

Түлхүүр үг:

Хүүхэд
Хоол тэжээл
Хооллолтын зөвлөгөө

Товч утга: Хүний нэгэн биеийн хөгжлийн эхэн үе болох нярай, бага насанд хүүхдийн бие бялдар болоод оюун ухаан нь өсөн хөгжиж байдаг тул хүүхдийг зохистой, амин дэм эрдэсээр баялаг, шим тэжээлтэй хооллоор хооллох нь нэн чухал юм[1]. **Зорилго:** Хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутагдлыг илрүүлэх, эмчлэх, бага насны хүүхдийн гэрийн эргэлт ба нялхас, бага насны хүүхдийн хооллолтын талаарх асран хамгаалагчийн мэдлэг хоорондын хамаарлыг судлах. **Арга, аргачлал:** Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн 2020 оны 09 дүгээр сараас 2021 оны 12 дугаар сарын хооронд аналитик судалгааны агшингийн загвар ба Кохорт судалгааны проспектив чиглэлээр хийж гүйцэтгэсэн. **Үр дүн:** Илрүүлэг үзлэгт хамрагдсан нийт хүүхдийн дунд өсөлтийн хоцрогдолтой 2.1%, тураал 1,56%, туранхай 1.4%, илүүдэл жин 10,1%, харин хоол тэжээлийн цочмог дутагдалтай 223 хүүхэд илэрсэн ба тэдгээрийн 38% нь эрэгтэй хүүхэд байв. **Дүгнэлт:** 1. Нялхас, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөх чавдар хангалтгүй байна. 2. Хүүхдийн хооллолтын талаарх эхчүүдийн хандлага бүх үзүүлэлтийн хувьд 50%-иас дээш буюу хангалттай байна. 3. Сонгинохайрхан дүүрэгт хоол тэжээлийн цочмог дутагдал илэрсэн хүүхэд нийт хүүхдийн 1,4%-ийг эзэлж байсан ба улсын дундажтай ижил түвшинд байна.

Үндэслэл: Хүний нэгэн биеийн хөгжлийн эхэн үе болох нярай, бага насанд хүүхдийн бие бялдар болоод оюун ухаан нь өсөн хөгжиж байдаг[1-3]. Тиймээс амьдралын энэ үед хүүхдийг зохистой, амин дэм эрдэсээр баялаг, шим тэжээлтэй хооллоор хооллох нь нэн чухал юм[2,3]. Хоол тэжээлийн дутагдал ба илүүдэлтэй холбоотой өвчин эмгэгийн улмаас дэлхийд жил бүр 3.5 сая гаруй эхчүүд, бага насны хүүхэд нас барж байна. Хүүхдийн амьдралын эхний жилүүдийн хоол тэжээлд нэн шаардлагатай шимт бодисууд дутагдсны улмаас өсөлт хөгжил хоцрох, цус багадалт, рахит, А аминдэмийн дутагдал зэрэг эмгэгүүд үүсдэг. Хоол тэжээлийн дутагдал нь бие бялдар, оюун ухааны хөгжилд сөргөөр нөлөөлж, улмаар эргэшгүй өөрчлөлтөнд орсны улмаас хойшдын эрүүл мэнд, амьдрах чадамж, амьдралын чанарт нь сөргөөр нөлөөлдөг байна[4,10]. Бага насны хүүхдүүдийн дундах нас баралтыг бууруулах, хоол тэжээлийн дутагдлаас үүдэлтэй өвчин эмгэгээс сэрийлэх хамгийн үр дүнтэй арга нь хүүхдийг эхийн сүүгээр, тохирсон нэмэгдэл хоолоор хооллох, хүүхдийн хоол, хүнсийг А аминдэм, цайр зэрэг шаардлагатай аминдэм, эрдэс бодисын нэмэлтээр баяжуулах, хоол тэжээлийн хурц дутагдлыг зөв эмчлэх гэх мэт арга хэмжээнүүд чухал болох нь тогтоогдоод байна[5].

Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдлын гол шалгуур үзүүлэлт болох бага жинтэй төрөлт, 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хоцролт, тураал, рахит, цус багадалт тогтвортой буурахгүй хэвээр байна.

Хүүхдийн хооллолтын байдал улмаар өсөлт хөгжилт насандаа тохирсон байхад асрамжлагч ба эхийн нярай, бага насны хүүхдийн хооллолтын

талаарх мэдлэг, хандлага дадал маш чухал юм. Эхчүүд, асран хамгаалагчдын нялхас, бага насны хүүхдийн хооллолтын талаарх мэдлэг, хандлагыг судалж, энэ талаар үнэлгээ, дүгнэлт хийсэн судалгааны тоо баримт ховор байдаг[6,9].

НЭМГ, НҮБХС-аас хамтран хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд хүүхдийн хооллолтын зөвлөгөөг цахимаар үргэлжлүүлэх, тасалдуулахгүй байх зарчмыг баримтлан ажиллаж байгаа билээ.

Зорилго: Хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутагдлыг илрүүлэх, эмчлэх, бага насны хүүхдийн гэрийн эргэлт ба нялхас, бага насны хүүхдийн хооллолтын талаарх асрамжлагчийн мэдлэг хоорондын хамаарлыг судлах

Зорилт:

1. Хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутагдлыг илрүүлэн, эмчилгээнд хамруулах
2. Хүүхдийн гэрийн эргэлтийн үеийн хүүхэд хооллолтын мэдээлэл хүрсэн байдлыг үнэлэх
3. Хүүхдийн гэрийн эргэлтийн хүүхэд хооллолтын талаарх эцэг, эхийн мэдлэгт үзүүлж буй нөлөөллийг хэмжих

Арга, аргачлал: Судалгааг Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн 2020 оны 09 дүгээр сараас 2021 оны 12 дугаар сарын хооронд аналитик судалгааны агшингийн загвар ба Кохорт судалгааны проспектив чиглэлээр хийж гүйцэтгэсэн.

Үр дүн: Нийт судалгаанд хамрагдсан эхчүүдийн статистик үзүүлэлтүүдийг хүснэгт 1-д харуулав. Эхчүүдийн боловсролын байдлыг хувиар илэрхийлэхэд дараахь байдалтай байна. Бага боловсролтой эхчүүдийн эзлэх хувь 1.6**%,** дунд боловсролтой эхчүүдийн эзлэх хувь 25.6**%,** дээд боловсролтой эхчүүдийн эзлэх хувь 72.7% байгаа нь эмчийн зүгээс зөвлөгөө өгөхөд боловсролын байдал нөлөөлж байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчийн ерөнхий үзүүлэлт

Үзүүлэлт	Тоо	Хувь	95% ИИ	
			Доод	Дээд
Эхийн боловсролын байдал				
Бага	2	1.6%	0.1%	3.8%
Дунд	31	25.6%	18.5%	33.9%
Дээд	88	72.7%	64.3%	80.1%
Эхийн нас	32.4	6.0	31.3	33.6


Тайлбар: ИИ – Итгэх интервал

Судалгаанд оролцсон эхчүүдийн 33.9%-д гэрийн эргэлтийн үед хүүхдийг зөв хооллох зөвлөгөөг өгөөгүй байв. Харин 11.6%-д хүүхдийг зөв хооллох зөвлөгөө өгсөн боловч хангалтгүй байв. Өрхийн эрүүл мэндийн төвөөс эхчүүдтэй утсаар холбогдох үед 25.6%-д буюу ¼-д зөв хооллолтын зөвлөгөөг хангалттай өгч, 66.1%-д зөв хооллолтын зөвлөгөөг огт өгөөгүй байв (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Утсаар хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгсөн байдал ба хүүхэд зөв хооллолтын талаарх мэдлэг

Үзүүлэлт	Утсаар хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгсөн эсэх					
	Өгөөгүй		Өгсөн боловч хангалтгүй		Өгсөн хангалттай	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хүүхдийг ангир уургийг амлуулсан эсэх						
Тийм	74	92.5	10	100.0	31	100.0
Үгүй	6	7.5	0	0.0	0	0.0
Ангир уураг нь хүүхдэд чухал ач холбогдолтой	80	100.0	10	100.0	31	100.0
Төрсний дараа хүүхдийг хөхөөр амлуулах нь чухал	80	100.0	10	100.0	31	100.0
Хүүхдийн зөвхөн хөхөөр хооллох хугацааг сонгоно уу						
2 нас	39	48.8	2	20.0	15	48.4
<3 сар	2	2.5	0	0.0	0	0.0
3-6 сар	3	3.8	0	0.0	1	3.2
<6 сар	36	45.0	8	80.0	15	48.4
Нэмэлт хоолонд оруулах тохиромжтой хугацааг сонгоно уу						
3 сар	1	1.3	0	0.0	0	0.0
6 сар	19	23.8	5	50.0	10	32.3
<6 сар	8	10.0	0	0.0	4	12.9
6 сар<	52	65.0	5	50.0	17	54.8
Хүүхдийг хэдэн нас хүртэл хөхөөр хооллох хэрэгтэй вэ**?**						
2 нас	70	87.5	10	100.0	29	93.5
3 сар	2	2.5	0	0.0	0	0.0
6 сар	8	10.0	0	0.0	2	6.5

Хүүхдийн өсөлт, хөгжлийн хэмжилтэнд 6-59 сартай 28685 хүүхэд хамруулахаас 53.7% буюу 15415 хүүхдийг хамруулсан байна. Тэдгээрийн 51% нь эрэгтэй хүүхэд байсан ба насны хувьд 34.8%-ийг 6 сар хүртэлх, 16.8%-ийг 7-11 сар, 17%-ийг 12-23 сар, 18%-ийг 24-36 сартай хүүхэд эзэлж байв. Илрүүлэг үзлэгт хамрагдсан нийт хүүхдийн дунд өсөлтийн хоцрогдолтой 2.1%, тураал 1,56%, туранхай 1.4%, илүүдэл жин 10,1%, харин хоол тэжээлийн цочмог дутагдалтай 223 хүүхэд илэрсэн ба тэдгээрийн 38% нь эрэгтэй хүйсийн хүүхэд байв. Хоол тэжээлийн цочмог дутагдал илэрсэн хүүхэд нийт хүүхдийн 1,4%-ийг эзэлж байсан ба тэдгээрийн 74% нь хүндэвтэр, 26% нь эмнэлзүйн хүндрэлгүй хүнд хүүхэд байсан. Хоол тэжээлийн цочмог дутагдал илэрсэн хүүхдийг насны хувьд авч үзэхэд 11.6% нь 6 сар хүртэлх насны хүүхдүүд байв(Зураг 1).



Зураг 1. Товлолт үзлэгийн үеийн хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгсөн байдал ба хандлага

Хэлцэмж: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан шалгуур үзүүлэлтээр тураалтай хүүхэд 10%-иас бага, өсөлт хоцролттой хүүхэд 20%-иас бага, туранхай хүүхэд 5%-иас бага байвал “Бага” тархалттай гэж үнэлдэг[7,8]. Энэхүү шалгууруар үнэлэхэд Монгол улсын 5 хүртэлх насны хүүхдийн дундах тураал, өсөлт хоцролт, туранхайн тархалт үндэсний түвшинд дээрх босго үзүүлэлтээс бага байгаа тул манай улс уураг илчлэг дутагдлын “Бага” тархалттай орны тоонд орсон байна.

Монгол Улсын Засгийн газраас 5 хүртэлх насны хүүхдийг хоол тэжээлийн дутагдлаас сэргийлэх, тархалтыг бууруулах чиглэлээр “Эх хүүхдийн хооллолтыг дэмжих”, “Бичил тэжээлийн дутагдлаас сэргийлэх бодлого”, баримталж, “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл”, “Хүнсний баталгаат байдал”, “Хүн амын хоол тэжээл” үндэсний арга хэмжээг шат дараалан хэрэгжүүлсний дүнд өсөлт хоцролт, тураалын тархалт тогтвортой буурсаар байна.

Дүгнэлт:

1. Нялхас, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөлтийн байдал хангалтгүй буюу гэрийн эргэлтийн үед 33.9%-д, утсаар холбогдох үед 66.1%-д хооллолтын зөвлөгөө өгөөгүй бол, 11.6%-д хооллолтын зөвлөгөө өгсөн боловч зөвлөгөөг хангалтгүй өгсөн байна.
2. Хүүхдийн хооллолтын талаарх эхчүүдийн хандлага бүх үзүүлэлтийн хувьд 50%-иас дээш буюу хангалттай байна.
3. Хоол тэжээлийн цочмог дутагдал илэрсэн хүүхэд нийт хүүхдийн 1,4%-ийг эзэлж байсан ба тэдгээрийн 74% нь хүндэвтэр, 26% нь эмнэлзүйн хүндрэлгүй хүнд хүүхэд байсан нь улсын дундажтай ижил түвшинд байна.

Ном зүй:

1. *Dandekar, R. H., Shafee, M., & Kumar, R. (2014). Breastfeeding and weaning practices among literate mothers A community based study in rural area of Perambalur taluk, Tamil Nadu.*
2. *Salama, A., Elhawary, D., El-Nmer, F. (2014). Nutritional knowledge, attitude, and practice of parents and its impact on growth of their children. Menoufia Medical Journal, 27(3), 612.*
3. *United Nations Children‘s Fund (UNICEF). (2013). Improving Child Nutrition The Achievable imperative for global progress. New York, US.*
4. *The Lancets series on Maternal and Child Undernutrition Executive Summary, The Lancet, 2010*
5. *Who.int. n.d. Malnutrition. [online] Available from: Cited on 2020 on Aug 10.*
6. *Rchiips.org. 2018. [online] Available from: Cited on 2020 on Aug 10.*
7. *Park K. Park’s Textbook of Preventive and Social Medicine. (25th ed) 2019*
8. *Gopinath TT, Logaraj M, John KR. Assessment of nutritional status of children aged under five years in tribal population of Jawadhu hills in Tamil Nadu. Int J Comm Med Public Health. 2018;5:1041–6.*
9. *WHO Weight-for-height [Internet]. Who.int. Available from: Cited on 2020 on Aug 10.*
10. *6. Global Nutrition Targets 2025: Low birth weight policy brief [Internet] World Health Organization; Available from: Cited on 2020 Aug 5. Cited on 2020 Aug 10.*

Assessment of the current status of acute malnutrition in children under five in Songinokhairkhan district and nutritional counseling for infants and young children

Enkhjargal B[1], Oyunbolor G[1], Otgonbold J[3],Yesu E[2], Ganchuluu Z[4]

[1]Department of Prosthodontics, School of Dentistry, MNUMS
[1]School of Biomedicine, MNUMS
[2,3]Ulaanbaatar Health Department
[4]Songinokhairkhan District Health Center
E-mail: enhuush0003@gmail.com, Tel: 90088010

Background: Lack of essential nutrients in the first years of a child's life can lead to delayed growth, anemia, rickets, and vitamin A deficiency.
Aim: To assess acute malnutrition among under 5 years children and determine associated factors responsible.
Purpose: Detection of acute malnutrition in children and investigation of the relationship between home visits and caregiver knowledge of infant and young child nutrition.

1. Identify and treat acute malnutrition in children
2. Assess the availability of child nutrition information to the family during the home visit
3. Measure the impact of children's home visits on parental knowledge of child nutrition

Material and Methods: The survey was conducted between September 2020 and December 2021 in the Songinokhairkhan district primary health centers of Ulaanbaatar in the field of analytics model and prospective Cohort research.
Results: Mongolia is a country with the "low" prevalence of protein and caloric deficiency due to the fact that according to the WHO criteria, the prevalence of underweight and delayed growth in children under the age of 5 is lower than the national threshold.
Conclusion:

1. Nutritional counseling for infants and young children is inadequate. 33.9% of the survey participants did not receive nutrition counseling during home visits, 66.1% did not receive nutrition counseling during telephone calls, and 11.6% received nutrition counseling but it was not adequate.
2. Mothers' point of view towards child nutrition is above 50% for all indicators.
3. Children with acute malnutrition accounted for 1.4% of total children, of whom 74% were moderate and 26% were severe without clinical complications, which is at the same level as the national average.

Keywords: Child, nutrition, nutritional status